Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 140,424.9 мянган төгрөг буюу 2.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	36,223.1	570,443.7	534,226.6
Авлага	212,969.6	23,722.1	(189,247.5)
Бараа материал	532,171.8	402,334.2	(129,837.6)
Үндсэн хөрөнгө	4,170,319.7	4,095,609.1	(74,710.6)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>4,951,684.3</b>	<b>5,092,109.1</b>	<b>140,424.9</b>
Өглөг	202,040.7	2,584.0	(199,456.7)
Засгийн газрын хувь оролцоо	2,470,206.5	2,470,206.5	-
Хуримтлагдсан үр дүн	(111,070.0)	228,811.5	339,881.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,390,507.1	2,390,507.1	-
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,951,684.3</b>	<b>5,092,109.1</b>	<b>140,424.9</b>

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 570,443.7 мянган төгрөгт хүрч, 534,226.6 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу зарим зардлууд гаргаагүй, гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай;
- ✓ Авлага дансны үлдэгдэл 23,722.1 мянган төгрөгт хүрч 189,247.5 мянган төгрөгөөр буурсан нь ЭМДС-ийн санхүүжилт, төлбөртэй үйлчилгээний болон байгууллагаас авах авлагуудыг барагдуулсантай;
- ✓ Бараа материал дансны үлдэгдэл 402,334.2 мянган төгрөгт хүрч 129,837.6 мянган төгрөгөөр буурсан нь 2021 онд гарсан цар тахалтай холбоотойгоор эм эмнэлгийн хэрэгслийн нөөц бэлтгэсэн байсан бөгөөд хугацаа дуусах дөхсөн эм эмнэлгийн хэрэгслийг цэргийн төв эмнэлэг, япон монголын хамтарсан эмнэлэг рүү шилжүүлсэнтэй;
- ✓ Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,095,609.1 мянган төгрөгт хүрч, 74,710.6 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдэл тооцсонтой тус тус холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны төсвийн төсөлд санхүүжилтийн эх үүсвэрийг ЭМДС-аас 4,400,000.0 мянган, үндсэн үйл ажиллагааны орлогоос 965,975.8 мянган, туслах үйл ажиллагааны орлогоос 59,448.0 мянган, нийт зарлагыг 5,458,785.4 мянган төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг 50,000.0 мянган, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн зардлыг 591,710.3 мянган төгрөгөөр тус тус нэмж батлан, ЭМДС-аас 637,369.8 мянган, үндсэн үйл ажиллагааны орлого 4,248.5 мянган, туслах үйл ажиллагааны орлого 92,000.0 мянган төгрөгөөр нэмж баталсан нь гүйцэтгэлээр санхүүжиж байгаагаас шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,037,369.8 мянган төгрөгийг ЭМДС-аас, 1,003,585.9 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 59,540.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр ЭМДС-аас 5,183,395.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 1,209,899.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 69,176.9 мянган төгрөг, дээд шатны төсвөөс хуваарилсан орлогоос 35,518.6 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,968,252.9 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиас шалтгаалж, байр ашиглалттай холбоотой зардал 33,833.5 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 55,584.2 мянган, бараа үйлчилгээний бусад зардлыг 19,236.7 мянган, цалин хөлсний зардалд 23,589.1 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/төгрөгөөр/	
	Код	Нэр			Зөрүү	Биелэлт
1	33	ЭМДС, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	6,100,495,750.00	6,497,991,098.28	(397,495,348.28)	106.5
1.1	2101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,087,520,000.00	3,035,240,303.13	(52,279,696.87)	98.3
1.2	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,588,926,400.00	2,371,487,378.36	(131,439,021.64)	97.8
1.3	2102	Бусад зардал	424,049,350.00	400,461,186.70	(23,588,163.30)	94.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2023 оны 01 дүгээр сарын 25-аас 02 дугаар сарын 19-ны хооронд Хурц тооцоолол аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Наранчимэг, аудитор Д.Гансүх, аудиторын туслах О.Мөнхтуяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Э.Учралзаяа, захирал Д.Лхамсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хурц тооцоолол аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 6,616,405.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 99,246.0 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахгүй, ажилтан, албан тушаалтнууд гадаад, дотоод албан томилолтоор ажиллаагүй зэрэг зардлуудыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 33,833.6 мянган, дотоод албан томилолтын зардлаас 3,500.0 мянган, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 1,161.3 мянган төгрөгийн хэмнэлт тус тус гаргасан боловч дараах асуудлууд илэрсэн. Үүнд:

1. Байгууллагын төсвөөс 71.5 мянган төгрөгийн хэвлэл захиалгын зардал гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.3 "Хэвлэлийн захиалгын төлбөр" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах зөрчлийг давтан гаргахгүй байх, төлбөрийн акт тогтоох.

2. Байгууллагын төсвөөс тайлант онд сургалтын зардалд 320.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 "Төсвийн байгууллага, ... дараах зүйлсийг хориглоно", 15.2.3 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун,



дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэж заасантай нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах зөрчлийг давтан гаргахгүй байх, төлбөрийн акт тогтоох.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих орлогын 6,428,630.9 мянган, зарлагын 4,497,828.0 мянган, нийт 10,926,458.9 мянган төгрөгийн 172 мэдээллээс 169 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 28,395.2 мянган төгрөгийн 3 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөх.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 33,571.1 мянган төгрөгийн 5 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад алдаа, зөрчлийг бүрэн залруулсан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 14,936.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
	Төлбөрийн акт	1	97.8	1	97.8
Зөвлөмж	2	14,838.3	2	14,838.3	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>14,936.1</b>	<b>3</b>	<b>14,936.1</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагаас авах 23,722.1 мянган төгрөгийн авлага үүссэн асуудлыг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 64,326.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 391.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 34,617.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 29,317,6 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 33,571.1 мянган төгрөгийн алдаа илэрснээс, аудитын явцад алдааг бүрэн залруулав.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- ✓ 28,448.1 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулсныг;
- ✓ Сузурфарм ХХК-ийн 2,600.0 мянган, Батбайгаль ХХК-ийн 1,450.0 мянган, Голомт банкны 100.0 мянган, Шүрэнтамга ХХК-ийн 350.0 мянган, нийт 4,500.0 мянган төгрөгийн түрээсийн барьцаануудыг өр төлбөрөөр бус орлогоор бүртгэснийг;
- ✓ Цалин тооцохдоо Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг 623.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тооцсон зэргийг тайлант оны жилийн эцэст залруулсан.

### 5.1 Төлбөрийн акт

Байгууллагын төсвөөс хэвлэл захиалгын 71.5 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.3 "Хэвлэлийн захиалгын төлбөр" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг арилгаж, 71.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

Тайлант онд 15 төрлийн сургалтад 9,678.4 мянган төгрөг зарцуулснаас 320.0 мянган төгрөгийн сургалтын зардал нь тэвчиж болох зардал байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 "Төсвийн байгууллага, ... дараах зүйлсийг хориглоно", 15.2.3 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг арилгаж, 320.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

### 5.2 Албан шаардлага

Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч "Манхан өгөөж" ХХК-ийн тендерт шалгарч, гэрээ байгуулсан үнээс нь 4.5-120 хувиар нэмэгдсэн үнээр худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйл "Худалдан авах гэрээнд нэмэлт, өөрчлөлт хийхийг хориглох...", 41.1.2 "энэ хуулийн 40.4, 40.6-д зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх", Сангийн сайдын 2021 оны 144 дүгээр тушаал "Бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг"-ийн 20.5 "Хууль болон Төрийн өмчийн хороонд өөрөөр заагаагүй бол тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. ТӨХ-д үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх хуулийг мөрдөн ажиллах, 6,221.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

Шилэн дансны цахим сайтад 28,395.2 мянган төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" гэж заасантай нийцээгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. **Зардал данстай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Харшлаас сэргийлэх ажилд 5 ажилтан 4 бүсчлэлээр 2022.07.13-2022.08.25-ны хугацаанд үе шаттайгаар ажилласан. Ингэхдээ 1 хүний өдрийн томилолтын зардлыг 25.0 мянган төгрөгөөр тооцсон нь Сангийн сайдын тогтоосон томилолтын тарифаас 2.6 дахин бага байгаа нь ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд санхүүгийн нөөц дутагдах эрсдэлтэй байна. Энэ нь Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал "Төрийн албан хаагчийн дотоод албан томилолтын зардлын тариф"-тай нийцээгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Томилолтын мөнгийг тарифын дагуу зөв тооцох, зөрчлийг давтан гаргахгүй байх.

#### 2. **Хөрөнгийн данстай холбоотой асуудал**

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 171 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3-д "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн байгууллагатай зөвшилцөж тогтоох" гэж заасантай нийцээгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Өртгөө бүрэн нөхсөн хөрөнгүүдийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн шийдэж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

#### 3. **Бараа материалын данстай холбоотой асуудал**

Тайлант онд орлого аваад, огт зарлагадаагүй 31 нэр төрлийн 13,653.4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл байгааг зайлшгүй нөөц гэж тайлбарлаж байгаа боловч зайлшгүй нөөцийн жагсаалт, баталсан тушаал шийдвэр байхгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйл 24.6 "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ" гэж заасантай нийцээгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Эм, эмнэлгийн хэрэгслийн зайлшгүй нөөцийн жагсаалтыг бэлтгэж, хянаж, байгууллагын удирдлагаар батлуулан мөрдөж ажиллах

#### 4. **Бараа материалын данстай холбоотой асуудал**

Тайлант хугацаанд огт зарлагадаагүй 28 нэр төрлийн 12,379.3 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл байна. Үүнд ковид цар тахлын үед хандиваар ирсэн, ЭМЯ-аас хуваарилсан, тухайн байгууллагын үйл ажиллагаанд хэрэглээгүй эм, эмнэлгийн хэрэгслүүд байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын Хавсралт 1-ийн 6-д "Бараа материал бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна" гэсэн заалттай нийцээгүй, "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.



Өгсөн зөвлөмж:

Цаашид хэрэглэхгүй эм, эмнэлгийн хэрэгслийн үлдэгдлийн судалгааг гаргаж, дээд шатны байгууллагад танилцуулан, хугацаа дуусахаас өмнө шаардлагатай байгаа эмнэлгийн байгууллагад шилжүүлэх арга хэмжээг авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 1 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



## 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сузурфарм ХХК, Батбайгаль ХХК, Голомт банк, Шүрэнтамга ХХК-ийн түрээсийн барьцаануудыг өр төлбөрөөр бус орлогоор бүртгэсэн.	1	4,500.0			1	4,500.0	1	4,500.0				
28,448.1 мянган төгрөгийн өр төлбөртэй.	1	28,448.1			1	28,448.1	1	28,448.1				
Цалин тооцохдоо ХХОАТ-ын хөнгөлөлтийг буруу тооцсон	1	623.0			1	623.0	1	623.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>33,571.1</b>			<b>3</b>	<b>33,571.1</b>	<b>3</b>	<b>33,571.1</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд хэвлэл захиалгын зардал гаргасан байна.	1	71.5	1	71.5								
Тайлант онд 15 төрлийн сургалтнаас тэвчиж болох зардал байна.	1	320.0	1	320.0								
1 хүний 1 өдрийн томилолтын зардлыг 25.0 мянган төгрөг буюу Сангийн сайдын тогтоосон дүнгээс 2.6 дахин бага байна.	1	3,284.9					1	3,284.9				
Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч "Манхан өгөөж" ХХК-ийн хүсэлтийн дагуу тендерт шалгарч, гэрээ байгуулсан үнээс нь 4.5-120 хувиар нэмэгдсэн үнээр худалдан авалт хийсэн байна.	1	6,221.8			1	6,221.8						
АӨСҮТ-ийн үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 171 нэр төрлийн	1	-					1	-				



Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

хөрөнгө бүртгэлтэй байна.												
Орлого аваад, огт зарлагдаагүй 31 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нөөцөлсөн байна	1	13,653.4					1	13,653.4				
Тайлант хугацаанд огт хэрэглэгдэхгүй 28 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслүүд байна.	1	12,379.3					1	12,379.3				
Шилэн дансны цахим сайтад 3 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	28,395.2			1	28,395.2						
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>64,326.1</b>	<b>2</b>	<b>391.5</b>	<b>2</b>	<b>34,617.0</b>	<b>4</b>	<b>29,317.6</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансны цахим сайтад гүйлгээг мэдээлээгүй байна.	1	28,395.2			1	28,395.2						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>28,395.2</b>			<b>1</b>	<b>28,395.2</b>						





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 дугаар сарын 24

№ 76/А0150127

Улаанбаатар хот

СНАГ-2023/349/НА-СТА-ТНУЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд сургалтад 320,000.00 төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, ... дараах зүйлсийг хориглоно", 15.2.3-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Тайлант онд сургалтад зарцуулсан 320,000.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Уранчимэг, ахлах нягтлан бодогч Б.Мядаг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ч.БОЛД

ХУРЦ ТООЦООЛОЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Д.ЛХАМСҮРЭН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 дугаар сарын 24 № 77/АД150127  
СНАГ-2023/349/НА-СТА-ТШЗ  
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хэвлэл захиалгын 71,500.00 төгрөгийн зардал гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.3-д "Хэвлэлийн захиалгын төлбөр" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тайлант онд зарцуулсан хэвлэл захиалгын 71,500.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Уранчимэг, ахлах нягтлан бодогч Б.Мядаг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХУРЦ ТООЦООЛОЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

Ч.БОЛД

Д.ЛХАМСҮРЭН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 24 № 254/А0150124

Улаанбаатар хот

СНАГ-2023/349/НА-СТБ-ТНЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч "Манхан өгөөж" ХХК-ийн тендерт шалгарч, гэрээ байгуулсан үнээс нь 4.5-120 хувиар нэмэгдсэн үнээр худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-т "Худалдан авах бараа, ажил үйлчилгээний тоног төхөөрөмж, үндсэн материал, түүхий эд, хөдөлмөрийн хөлсний үнэд захиалагч дараах тохируулга хийхээр гэрээнд тусгаж болно", 40.4.2-т "суурь үнэ огцом өөрчлөгдсөн" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч "Манхан өгөөж" ХХК-аас нэмэгдсэн үнээр худалдан авалт хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Уранчимэг, ахлах нягтлан бодогч Б.Мядаг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ХУРЦ ТООЦООЛ ОЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Ч.БОЛД

Д.ЛХАМСҮРЭН







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 24 № 255/А0150127

Улаанбаатар хот

СНАГ-2023/349-НА-ОГА-143  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд зарлагын 28,395,200.00 төгрөгийн 3 гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Уранчимэг, ахлах нягтлан бодогч Б.Мядаг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ХУРЦ ТООЦООЛОЛ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Ч.БОЛД

Д.ЛХАМСҮРЭН